

Батлав:
"Натурал Текстайл Групп" ХХК-ийн
Гүйцэтгэх Захирал
/О.МӨНХЦАЦРАЛ/

Батлав:
"ЦЕГ"-ын СААА-ны Дарга,
Цагдаагийн хуралдаа
/Ж.ЭРДЭНЗБОЛД/

ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2018 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 33

Улаанбаатар хот

Нэг талаас: Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 2-р хороо Чингисийн өргөн чөлөөнд байрлах, Регистрийн 2030314 дугаартай, "Натурал Текстайл Групп" ХХК-н төлөөлөгчийн газар /цаашид "Худалдагч" гэх/, түүнийг төлөөлөн менежер Энхбаатар овогтой Уянга,

Нөгөө талаас: Цагдаагийн Ерөнхий Газар /цаашид "Худалдан авагч" гэх/, түүнийг төлөөлж ЗУГ-ын аж ахуйн ажилтан цагдаагийн дэслэгч Х.Бат /цаашид хамтад нь "Талууд" гэх/ Монгол Улсын Иргэний Хуулийн 243-261 дугаар зүйлүүд болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээнд заасны дагуу Худалдагч болон Худалдан авагч тал нь биет байдлын болон эрхийн доголдолгүй барааг бэлдэж, харилцан хүлээлцэж өгөх бөгөөд гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.
- 1.2 Барааны нэр, төрөл: Чингис дорж – тусгай захиалга
- 1.3 Барааг нийлүүлэх хугацаа: 2018 оны 5 сарын 22 өдөр
- 1.4 Барааны нийт үнийн дүнг хүснэгт хэлбэрээр Хавсралт №1-т орууллаа

Хоёр. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл.

- 2.1 Барааны нийт үнийн дүнгийн тооцооллыг хүснэгтээр үзүүлээ:

Хавсралт №1

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Үндсэн үнэ	Хямдарсан үнэ	Хямдралын хувь	Тоо, хэмжээ	Нийт үнэ /төгрөг/
1	4R0027/021	м2	65 000	58 500	10%	300.56	17 582 760
2	Ажлын хөлс	м2	5 000	1 000	80%	300	300 000
Нийт							17 882 760

- 2.2 Барааны нийт үнэ нь: 17,882,760 (Арван долоон сая найман зуун наян хоёр мянга долоон зуун жар) төгрөг болно. Үүнд НӨАТ орсон болно.

- 2.2.1 Нийт гэрээний үнийн дүнг дараах төлбөрийн нөхцлөөр төлнө. Худалдан авагч нь гэрээний нийт үнийн дүнгийн 50 хувь болж 8,941,380 /Найман сая есөн

Худалдагчийг төлөөлж:



Худалдан авагчийг төлөөлж:



зуун дөчин нэгэн мянга гурван зуун ная/ төгрөгийг урьдчилгаа болгон гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш худалдагчийн нэхэмжлэлийг үндэслэн ажлын 3 хоногийн дотор шилжүүлнэ.

2.2.2 Бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа үлдэгдэл төлбөр 50 хувь болох 8,941,380 /Найман сая есөн зуун дөчин нэгэн мянга гурван зуун ная/ төгрөгийг шилжүүлнэ.

2.2.3 Төлбөр шилжүүлэх дансны мэдээлэл: Төлбөрийг бэлэн бусаар "Натурал Текстайл Групп" ХХК-ийн Голомт банк дахь 4005016385 тоот дансанд шилжүүлнэ.

Гурав. Худалдагч талын эрх, үүрэг

- 3.1 Худалдагч тал нь дараах үүрэг хүлээнэ
- 3.1.1 Худалдан авагчийн үйл ажиллагааны шаардлагыг хангасан, урьдчилан тохиролцсон чанар, стандарт, тоо хэмжээ бүхий барааг нийлүүлэх
- 3.1.2 Нийлүүлсэн бараа нь чанарын шаардлага хангахгүй эсвэл энэхүү гэрээнд зааснаас өөр эсвэл дутуу бол чанарын шаардлага хангахуйц түвшинд засварлах, гүйцээн нийлүүлэх
- 3.1.3 Энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх үүрэгтэй
- 3.2 Худалдагч тал нь дараах эрх эдлэнэ
- 3.2.1 Гэрээнд заасан хугацааны дагуу төлбөр тооцоогоо төлөхийг Худалдан авагч талаас шаардах эрхтэй
- 3.2.2 Энэхүү гэрээгээр заасан бусад үүргээ биелүүлэхийг Худалдан авагч талаас шаардах эрхтэй

Дөрөв. Худалдан авагч талын эрх, үүрэг

- 4.1 Худалдан авагч нь дараах үүрэг хүлээнэ
- 4.1.1 Барааны үнийг энэхүү гэрээний 2-р зүйлд заасан нөхцлөөр Худалдагч талын нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлэх
- 4.1.2 Барааг холбогдох бичиг баримтын дагуу шуурхай хүлээн авах
- 4.1.3 Барааг хүлээн авахдаа тодорхой хариуцсан ажилтан хүлээж авах ба хүлээж авснаас хойш барааны бүрэн бүтэн байдал тоо хэмжээг хариуцах
- 4.1.4 Энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх үүрэгтэй
- 4.2 Худалдан авагч нь дараах эрх эдлэнэ
- 4.2.1 Худалдагч талаас заасан хугацаанд захиалсан бараагаа чанарын дагуу заасан тоо хэмжээгээр авахыг шаардах
- 4.2.2 Худалдагч талаас нийлүүлсэн бараа материал нь чанар стандартын шаардлага хангаагүй, биет байдлын доголдолтой тохиолдолд уг доголдлыг арилгуулах буцаан солихыг худалдагч талаас шаардах
- 4.2.3 Энэхүү гэрээгээр заасан бусад үүргээ биелүүлэхийг Худалдагч талаас шаардах эрхтэй

Тав. Талуудын хүлээх хариуцлага

Худалдагчийг төлөөлж:



Худалдан авагчийг төлөөлж:



N.T.G.
NATURAL TEXTILE GROUP

- 5.1 Худалдан авагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс 0.3%-ийн алданги төлнө.
- 5.2 Худалдагч тал энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэлгүй чанарын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд Худалдан авагч нь уг барааг буцаан хүлээлгэн өгч, үнийн дүнгээ шаардана.
- 5.3 Алданги торгуулийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй болно.

Зургаа. Бусад зүйл


- 6.1 Холбогдох хууль тогтоомжинд заасан гэнэтийн давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол талуудын харилцан тохиролцоог үндэслэн шийдвэрлэнэ.
- 6.2 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэж чадаагүй тохиолдолд зохих шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.3 Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

(Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж баталгаажуулав)


Худалдагч талыг төлөөлж:

"Натурал Текстайл Групп" ХХК-ийн
 Менежер 
 /О.Уянга/
 Утас: 99097889


"Натурал Текстайл Групп" ХХК-ийн
 Ахлах менежер 
 /Ө.Болор-Эрдэнэ/
 Утас: 99113814

"Натурал Текстайл Групп" ХХК-ийн
 СЭЗНББГ-ын Захирал 
 /Л.Хангарьд/
 Утас: 99105806

Худалдан авагч талыг төлөөлж:

"ЦЕГ"-ын ЗУГ-ын Аж ахуйн ажилтан
 Цагдаагийн дэслэгч 
 /Х.Бат/
 Утас: 70191079

Гэрээг хянасан:

"ЦЕГ"-ын Санхүүгийн Хэлтсийн Дарга
 Цагдаагийн хурандаа 
 /Н.Алтансүх/
 Утас: 70191079

Худалдагчийг төлөөлж:



Худалдан авагчийг төлөөлж:

